



DEFENSE RESEARCH
INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.01.004>

National Security Legal Frameworks: Comparative Analysis and Mongolia

Dashzeveg Batbayar¹, Shijee Palamdorj²

¹Ph.D Candidate, Senior researcher, Center for security studies, Defense Research Institute of Mongolia
E-mail address: batbayar007@gmail.com, ORCID: 0009-0000-6601-6193

²Sc.D, Professor, Leading researcher, Center for military art, Defense Research Institute of Mongolia
E-mail address: Palamdorjsh1948@gmail.com, ORCID: 0009-0008-6114-1698

Received: 13 February 2026
Accepted: 15 March 2026

Revised: 27 February 2026
Published online: 30 March 2026



ABSTRACT

The contemporary international security environment has evolved beyond the traditional military-political paradigm and has assumed an expanded and integrated character encompassing economic, energy, cyber technological, infrastructural, and human security dimensions. This transformation has generated a systemic need to reform and modernize the legal framework governing national security. This article comparatively examines the legal regulation and developmental trends of national security by analyzing the institutional and strategic policy experiences of the United States and the Federal Republic of Germany.

The study identifies that strategic competition among states, economic interdependence, and vulnerabilities arising from technological transformation have necessitated an expanded substantive scope of national security law. It further delineates the pressing challenges faced by Mongolia in aligning its legal and policy framework with contemporary security realities, particularly in relation to its geostrategic location, economic structure, dependence on energy and infrastructure systems, and the current state of cyber security regulation.

Keywords: Mongolia, National Security, Legal Framework, Comprehensive Security, Geopolitics, Cybersecurity, Critical Infrastructure, Comparative Law.

Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчин: харьцуулалт ба Монгол Улс

Дашзэвэг Батбаяр¹, Шижээ Паламдорж²

¹Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, E-mail address: batbayar007@gmail.com, ORCID: 0009-0000-6601-6193

²Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн Цэргийн урлаг судлалын төвийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор,
Palamdorjsh1948@gmail.com, ORCID:0009-0008-6114-1698

ХУРААНГУЙ

Орчин үеийн олон улсын аюулгүй байдлын орчин нь уламжлалт цэрэг-улс төрийн ойлголтоос

давж, эдийн засаг, эрчим хүч, кибер технологи, дэд бүтэц, хүний аюулгүй байдлыг хамарсан өргөтгөсөн, нэгдмэл шинжтэй байна. Энэхүү өөрчлөлт нь үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг системийн түвшинд шинэчлэх шаардлагыг бий болгож байна. Тус өгүүлэлд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт, хөгжлийн чиг хандлагыг харьцуулж АНУ болон ХБНГУ-ын аюулгүй байдлын институцийн болон стратегийн бодлогын туршилагыг судлан үзлээ.

Улс орнуудын стратегийн өрсөлдөөн, эдийн засгийн хамаарал, технологийн өөрчлөлт бүхий эмзэг байдал нь үндэсний аюулгүй байдлын эрх зүйг агуулгын хүрээнд өргөжүүлэн судлахыг тодорхойлсон. Мөн Монгол Улсын геостратегийн байршил, эдийн засгийн бүтэц, эрчим хүч болон дэд бүтцийн хараат байдал, кибер аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн түвшинд нийцүүлэн тулгамдаж буй сорилтуудыг тодорхойлсон болно.

Түлхүүр үг: *Монгол Улс, Үндэсний аюулгүй байдал, Эрх зүйн орчин, Нэгдмэл аюулгүй байдал, Геополитик, Кибер аюулгүй байдал, Стратегийн дэд бүтэц, Харьцуулсан эрх зүй.*

Орчин үеийн олон улсын харилцаа шинэ хэмжигдэхүүнээр тодорхойлогдох болсноор үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг өргөтгөсөн, системчилсэн агуулгаар шинээр тодорхойлох зүй ёсны шаардлага бий болж байна. Аюулгүй байдлын ойлголт нь зөвхөн цэрэг-улс төрийн хүрээгээр хязгаарлагдахгүй болж, эдийн засаг, эрчим хүч, технологи, хүний аюулгүй байдлыг хамарсан цогц, нэгдмэл шинжийг илэрхийлэх болсон. Иймд аюулгүй байдлын ойлголт өргөжин тэлж, олон салбарыг хамрах болж түүнийг зохицуулах эрх зүйн орчны бүтэц, хамрах хүрээ, зохицуулалтын арга хэрэгслийг шинэ шатанд авч үзэх шаардлага тавигдаж байна (*Buzan 1998*).

Харьцуулсан судалгаанаас үзэхэд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын эрх зүйн тогтолцоо, төрийн байгуулалтын хэлбэр, стратегийн сонирхол, геополитикийн байршлаас хамааран ялгаатай хөгжиж иржээ. Эх газрын эрх зүйн тогтолцоонд парламент, хууль тогтоомж давамгайлдаг бол нийтлэг эрх зүйд шүүхийн жишиг, гүйцэтгэх засаглалын бодлогын баримт бичиг илүү нөлөөлж байдаг.

АНУ-ын үндэсний аюулгүй байдлын институцийн зохион байгуулалт нь стратегийн удирдлага, тагнуул, батлан хамгаалах бодлогын уялдааг хангаж чадсан нэгдмэл тогтолцоогоороо олон улсын хэмжээнд жишигт тооцогддог. 1947 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлагдсанаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын төв газар, Батлан хамгаалах яамны орчин үеийн бүтэц бүрэлдэн тогтсон. Энэхүү институцийн загвар нь стратегийн төлөвлөлт, тагнуул, батлан хамгаалах бодлогыг нэгтгэн удирдах боломжийг бүрдүүлсэн байдаг ба дэлхийн зарим нэг улс орнууд энэ жишгээр тогтолцоондоо ч өөрчлөлт хийсэн байдаг.

2001 оны террорист халдлагын дараа АНУ дотоод аюулгүй байдлын тогтолцоогоо эрс шинэчилж, Дотоодын аюулгүй байдлын яамыг байгуулсан нь терроризм, хил хамгаалалт, онцгой байдлын удирдлагыг нэгдсэн системд оруулсан стратегийн реформын шинэчлэл болсон. Энэ нь дотоод болон гадаад аюулгүй байдлын уялдаа ямар чухал болохыг харуулсан бодит жишээ юм.

ХБНГУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид “нэгдмэл аюулгүй байдал” гэсэн ойлголтыг нэвтрүүлж, аюулгүй байдлыг цэрэг-улс төрөөс гадна эдийн засаг, эрчим хүч, технологи, уур амьсгалын эрсдэлтэй уялдуулан тодорхойлсон нь Европын орнуудад аюулгүй байдлыг цогцоор нь авч үзэх чиг хандлагыг

бодитойгоор хэрэгжүүлсэн анхны туршлагаудын нэг гэж үзэх үндэслэлтэй. Баруун Европт өрнөж буй геополитикийн сэргөлдөөний нөхцөл байдал нь эрчим хүчний хараат байдлыг зөвхөн эдийн засгийн бус, үндэсний аюулгүй байдлын стратегийн эрсдэл хэмээн үнэлэхэд хүргэсэн нь аюулгүй байдлын эрх зүйн бодлого салбар дундын шинжээр өргөжин хөгжиж буйг илтгэж байгаа юм.

Монгол Улсын геополитикийн өвөрмөц байршил, эдийн засгийн бүтцийн онцлог, гадаад орчны нөлөөллөөс хэт хамааралтай байдал нь үндэсний аюулгүй байдлын эрх зүйг тэнцвэртэй, урт хугацааны стратегийн хэмжээнд төлөвлөх шаардлага бий болж байна. Кибер аюулгүй байдал, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн хамгаалалт, ханган нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна (*Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010*).

Иймд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн шинэчлэлийг дотоод ардчиллын бэхжилт, олон улсын хамтын ажиллагаа, нэгдмэл аюулгүй байдлын тогтолцоонд тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй юм. Энэ нь зөвхөн хамгаалах бус, улс орны тогтвортой хөгжил, стратегийн бие даасан байдлыг баталгаажуулах институцийн үндсэн суурь нөхцөл болох учиртай (*Алсын хараа-2050 2020*).

АНУ ба ХБНГУ-ын үндэсний аюулгүй байдлын эрх зүйн тогтолцооны харьцуулсан шинжилгээ

АНУ нь үндэсний аюулгүй байдлын институцийн нэгдмэл, төвлөрсөн загварыг бүрдүүлсэн орнуудын сонгодог жишээнд тооцогддог. Дэлхийн II дайны дараах геополитикийн шинэ орчин, Хүйтэн дайны стратегийн өрсөлдөөний нөхцөлд АНУ аюулгүй байдлын бодлогоо институцийн түвшинд нэгтгэн зохион байгуулах шаардлагатай болсон бөгөөд энэхүү хэрэгцээ шаардлагын үндсэн дээр 1947 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлагдсан юм (*National Security Act 1947*). Тус хуулиар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (NSC), Тагнуулын төв газар (CIA), Батлан хамгаалах яамны нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрэлдэн тогтож, стратеги төлөвлөлт, тагнуул, батлан хамгаалах бодлогын уялдаа институцийн түвшинд хангагдах болсон нь орчин үеийн аюулгүй байдлын засаглалын суурь загвар болжээ.

Энэхүү тогтолцооны дараагийн томоохон институцийн шинэчлэл нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа хэрэгжсэн. Дотоод аюулгүй байдлын эрсдэлийг гадаад аюулгүй байдлын бодлогоос салангид авч үзэх боломжгүй нь тодорхой болсон тул 2002 онд Дотоодын аюулгүй байдлын яам (Department of Homeland Security) байгуулагдсан. Энэ нь терроризмтой тэмцэх, хил хамгаалалт, кибер хамгаалалт, онцгой байдлын удирдлага, дотоод тагнуулын чиг үүргийг нэгтгэсэн цогц институцийн реформ байсан бөгөөд дотоод-гадаад аюулгүй байдлын уялдаа холбоог шинэ шатанд гаргасан стратегийн ач холбогдолтой алхам болсон (*Homeland Security Act 2002*).

АНУ-ын үндэсний аюулгүй байдлын эрх зүйн бодлогын чиг баримжаа нь Үндэсний аюулгүй байдлын стратегийн баримт бичгүүдээр илүү тодорхойлогддог. 2022 оны Үндэсний аюулгүй байдлын стратегид ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, технологи-эдийн засгийн манлайллыг хадгалах, холбоотны эвслийг бэхжүүлэх, системийн өрсөлдөгчидтэй стратегийн өрсөлдөөн явуулах зорилтыг

тодорхойлсон байна (*National Security Strategy 2022*). Тус стратегид БНХАУ-ыг олон улсын дэг журмыг өөрчлөх чадвартай системийн өрсөлдөгч, ОХУ-ыг шууд бөгөөд хурц аюул гэж тодорхойлсон нь геополитикийн үнэлгээ аюулгүй байдлын эрх зүйн бодлого, институцийн төлөвлөлтөд хэрхэн нөлөөлж байгааг тодорхой харуулдаг. Өөрөөр хэлбэл, АНУ-ын аюулгүй байдлын эрх зүйн тогтолцоо нь гадаад стратегийн манлайлал, эвслийн сүлжээ, технологийн давамгайлалд тулгуурласан “глобал төвтэй” загварт хамаарагддаг.

Харин ХБНГУ-ын хувьд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь түүхэн туршлага, ялангуяа Дэлхийн II дайны дараах энх тайванч, хязгаарлагдмал цэргийн бодлогоос үүдэн илүү болгоомжтой, институц хоорондын хяналт-тэнцэлд суурилсан шинжтэй хөгжсөн. Германы Үндсэн хууль буюу “Үндсэн хууль” (Basic Law)-д чөлөөт ардчилсан дэг журмыг хамгаалах, холбооны болон мужийн хамтарсан аюулгүй байдлын зохицуулалт, онцгой нөхцөлд зэвсэгт хүчин ашиглах эрх зүйн үндсийг нарийвчлан тусгасан байдаг (*National Security Strategy of Germany 2023*). Энэ нь дотоод аюулгүй байдал, иргэний хамгаалалт, холбооны бүтэц хоорондын уялдааг эрх зүйн түвшинд баталгаажуулсан онцлог зохицуулалт юм.

Германы аюулгүй байдлын эрх зүйн бодлого шинэ шатанд гарсан нь 2023 онд батлагдсан анхны Үндэсний аюулгүй байдлын стратегитай шууд холбоотой. Уг стратегид “нэгдмэл аюулгүй байдал” (Integrated Security) гэсэн ойлголтыг дэвшүүлж, аюулгүй байдлыг зөвхөн цэрэг-улс төрийн хүрээнд бус эдийн засаг, эрчим хүч, технологи, уур амьсгал, нийлүүлэлтийн сүлжээний тэсвэртэй байдалтай уялдуулан тодорхойлсон (*National Security Strategy of Germany 2023*). Үүнд:

- Цэргийн хамгаалалтын чадавхыг бэхжүүлэх;
- Эдийн засаг, технологийн хараат байдлыг бууруулах;
- Уур амьсгал, байгалийн нөөцийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван тулгуур чиглэл багтсан.

Тодруулбал, Орос-Украины хямарлын дараа Германы эрчим хүчний хамаарал үндэсний аюулгүй байдлын стратегийн эмзэг байдалд хүргэж болзошгүй болж, эрчим хүчний эх үүсвэрийг төрөлжүүлэх, стратегийн нөөц, нийлүүлэлтийн сүлжээний эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх бодлогыг идэвхтэй явуулж эхэлсэн байна. Энэ нь аюулгүй байдлын эрх зүйн бодлого эдийн засгийн бүтэц, гадаад худалдааны хамааралтай шууд уяллдагийг нотолсон бодит жишээ юм.

АНУ ба ХБНГУ-ын аюулгүй байдлын эрх зүйн тогтолцоог харьцуулан үзэхэд АНУ нь гадаад бодлогын хүрээнд манлайлах үүрэг, оролцоо, эвслийн системд тулгуурласан “олон улсын байр сууриа бэхжүүлэх” шинжтэй бол Германы загвар нь дотоод тогтвортой хөгжил, эдийн засаг-институцийн чадавхаа бэхжүүлэхэд тулгуурласан “нэгдмэл аюулгүй байдлын” гол чиглэл болж байна. Энэ ялгаа нь улс орнуудын түүхэн туршлага, геополитикийн байрлал, стратегийн сонирхлоос хамааран аюулгүй байдлын эрх зүйн бодлого өөр өөрөөр хөгждөг зүй тогтлыг тодорхой харуулж байна.

Стратегийн харьцуулалт ба Монгол Улсын аюулгүй байдлын эрх зүйн орчны сорилт

Эдийн засгийн өндөр хөгжилтэй зарим улс орнуудын стратегийн өрсөлдөөнөөр

тодорхойлогдох болсон олон улсын аюулгүй байдлын орчин нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын хөгжил, чиг хандлагад бодитой нөлөө үзүүлэх болсон. Ялангуяа АНУ болон ОХУ зэрэг цөмийн зэвсэгтэй, ашиг сонирхол бүхий аюулгүй байдлын бодлого нь олон улсын аюулгүй байдлын орчны чиг хандлагыг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Энэ утгаараа их гүрнүүдийн аюулгүй байдлын стратегийг харьцуулан судлах нь жижиг, дунд улсуудын эрх зүйн бодлогоо тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

АНУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги нь дэлхийн манлайллыг хадгалах, олон улсын либерал дэг журмыг хамгаалах, эвслийн системийг бэхжүүлэхэд чиглэсэн гадаад төвтэй шинжтэй байдаг. Тус улс НАТО болон бусад стратегийн түншлэлийн сүлжээгээр дамжуулан хамтын аюулгүй байдлын механизм бүрдүүлж, цэрэг-улс төр, технологи, эдийн засгийн нөлөөгөө дэлхийн хэмжээнд хадгалах бодлого баримталдаг. Ийм стратеги нь аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтад ч тусгалаа олж, батлан хамгаалах хамтын ажиллагааны гэрээ, цэргийн баазын эрх зүйн статус, хамтарсан ажиллагааны эрх зүйн орчныг өргөжүүлэхэд чиглэдэг (*Strategic Concept of NATO 2022*).

Харин ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги нь харьцангуй өөр чиг баримжаатай бөгөөд дотоод тогтвортой байдал, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, бүс нутгийн стратегийн нөлөөг хадгалахад түлхүү анхаардаг. Тус улсын стратегид төрийн нэгдмэл байдал, соёл иргэншлийн дархлаа, мэдээллийн аюулгүй байдал, барууны геополитикийн дарамтаас хамгаалах асуудал тэргүүлэх байр суурь эзэлдэг нь эрх зүйн зохицуулалтад ч мөн адил тусгагдсан байдаг (*National Security Strategy of the Russian Federation 2021*).

Эдгээр ялгааг олон улсын харилцааны онолын үүднээс тайлбарлавал Кеннет Уолтзын дэвшүүлсэн неореалист хандлага онцгой ач холбогдолтой. Түүний үзэж байгаагаар олон улсын тогтолцоо нь анарх шинжтэй бөгөөд улс орнууд аюулгүй байдлаа хангахын тулд хүчний харьцаанд тулгуурлан бодлогоо тодорхойлдог (*Theory of International Politics 1979*). Ийм нөхцөлд их гүрнүүд стратегийн орон зай, нөлөөллийн бүсээ хамгаалах зорилгоор аюулгүй байдлын эрх зүйн бодлогоо цэрэг-стратеги, эдийн засаг, технологийн чадавхтай уялдуулан хөгжүүлдэг байна.

Их гүрнүүдийн дээрх стратегийн ялгаа нь геополитикийн хувьд эмзэг байрлалтай жижиг, дунд улсуудын аюулгүй байдлын эрх зүйн бодлогод шууд нөлөөлдөг. Монгол Улсын хувьд Евразийн эх газрын төв хэсэгт, хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, экспортын бүтэц нь уул уурхайд төвлөрсөн, эрчим хүчний хамаарал өндөр зэрэг онцлог нь үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг онцгой нарийн тэнцвэртэй төлөвлөх шаардлагыг бий болгодог.

Тухайлбал, гадаад худалдааны экспортын ихэнх хувь нь хязгаарлагдмал зах зээлд төвлөрсөн, эрчим хүчний систем нь импортын хараат бүтэцтэй, стратегийн дэд бүтцийн нөөц хязгаарлагдмал зэрэг нь эдийн засгийн аюулгүй байдлын эрх зүйн баталгааг бэхжүүлэх шаардлагыг нэмэгдүүлж байна. Үүнээс гадна даяаршил, дижитал шилжилтийн эрчимжилттэй холбоотойгоор кибер аюулгүй байдал, мэдээллийн дайн, стратегийн өгөгдлийн хамгаалалт зэрэг шинэ төрлийн заналхийлэл нэмэгдэж, уламжлалт эрх зүйн зохицуулалтын хүрээнээс давсан сорилтуудыг бий болгож байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлагдан хэрэгжиж байгаа боловч орчин үеийн аюулгүй байдлын өргөжсөн ойлголтын хүрээнд дараах салбаруудын эрх зүйн зохицуулалт сул хэвээр байна. Үүнд: кибер аюулгүй байдлын нэгдсэн эрх зүйн тогтолцоо, стратегийн дэд бүтцийн хамгаалалтын хууль эрх зүй, эрчим хүч болон хүнсний стратегийн нөөцийн зохицуулалт, нийлүүлэлтийн сүлжээний тасралтгүй байдлыг хангах эрх зүйн баталгаа зэрэг багтах учиртай юм (*Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010*).

Ийнхүү их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн эрчимжиж буй нөхцөлд Монгол Улсын аюулгүй байдлын эрх зүйн орчин нь зөвхөн батлан хамгаалах салбарт төвлөрөх бус, геоэдийн засаг, кибер орон зай, дэд бүтцийн тэсвэр, стратегийн хараат байдлыг бууруулах бодлоготой уялдан шинэчлэгдэх шаардлагатай болж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдлын эрх зүйн бодлогыг “гаднаас хамгаалах” ойлголтоос “дотоод дархлааг бэхжүүлэх” нэгдмэл хандлагад шилжүүлэх онол-арга зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох бодлого чиглэл

Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал нь олон улсын, бүс нутгийн болон дотоодын түвшинд уялдаа бүхий нэгдмэл бодлогын шинжтэйгээр хэрэгжих шаардлагатай стратегийн зорилт юм. Орчин үеийн аюулгүй байдлын сорилтууд хил хязгаар үл хамаарах, харилцан хамааралтай шинжтэй болсон нөхцөлд эрх зүйн зохицуулалтыг олон түвшинд зэрэг хөгжүүлэх нь үндэсний аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэх суурь нөхцөл болдог (*Батбаяр 2026*). Олон улсын түвшинд Монгол Улс аюулгүй байдлын эрх зүйн орчноо бэхжүүлэхдээ итгэлцлийг бэхжүүлэх, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, хамтын аюулгүй байдлын механизмд идэвхтэй оролцох бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай. Итгэлцлийг бэхжүүлэх механизм нь зөвхөн улс төрийн тунхаглал бус, мэдээлэл солилцох, цэргийн ил тод байдлыг хангах, хамтарсан сургалт, хяналт-шинжилгээний эрх зүйн зохицуулалтыг багтаасан институцийн тогтолцоо байх ёстой. Ялангуяа жижиг, дунд улсуудын хувьд стратегийн тэнцвэрийг хадгалах, их гүрнүүдийн өрсөлдөөний сөрөг нөлөөллийг бууруулахад ийм механизм онцгой ач холбогдолтой.

Үүний зэрэгцээ зэвсэглэл хорогдуулах, үл дэлгэрүүлэх, итгэлцэл бэхжүүлэх хэлэлцээрүүдэд идэвхтэй оролцох нь Монгол Улсын олон улсын аюулгүй байдлын эрх зүйн байр суурийг бэхжүүлэх стратегийн хэрэгсэл болно. Цөмийн зэвсэггүй бүсийн статус, зэвсэг хураах олон улсын гэрээ, хяналтын механизмд оролцох замаар аюулгүй байдлын гадаад орчны эрсдэлийг бууруулах боломжтой. Ийм эрх зүйн оролцоо нь Монгол Улсын төвийг сахисан, энхийг эрхэмлэсэн гадаад бодлогын үзэл баримтлалтай нийцдэг.

Бүс нутгийн хэмжээнд Монгол Улс Ази-Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны санаачилгад идэвхтэй оролцох, харилцан итгэлцлийг бэхжүүлэх яриа хэлэлцээний платформуудыг дэмжих нь чухал ач холбогдолтой. Тус бүс нутаг нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн төв байхаас гадна цэрэг-стратегийн өрсөлдөөн, тэнгис далайн маргаан, зэвсэглэлээр хөөцөлдөх өрсөлдөөн зэрэг эрсдэл өндөртэй бүс нутагт тооцогддог. Ийм нөхцөлд бүс нутгийн аюулгүй байдлын яриа хэлэлцээ, урьдчилан сэргийлэх дипломат механизмд оролцох нь

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад баталгааг бэхжүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн Солонгосын хойгийн цөмийн асуудал, Зүүн хойд Азийн аюулгүй байдлын яриа хэлэлцээ, олон талт энхийн санаачилгуудыг дэмжих замаар бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах боломжтой. Энхийн хэлэлцээ, зуучлал, итгэлцэл бэхжүүлэх санаачилга нь Монгол Улсын “туравдагч хөршийн бодлого” болон энхийг дэмжих гадаад бодлогын эрх зүйн байр суурийг бэхжүүлэх давхар ач холбогдолтой.

Дотоодын түвшинд үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчны шинэчлэл нь орчин үеийн өргөтгөсөн аюулгүй байдлын ойлголттой уялдах шаардлагатай. Юуны өмнө кибер аюулгүй байдлын нэгдсэн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох нь нэн тэргүүний зорилт болж байна. Төрийн мэдээллийн систем, стратегийн өгөгдөл, санхүүгийн дэд бүтэц, харилцаа холбооны сүлжээ нь кибер халдлагад өртөх эрсдэл нэмэгдэж байгаа тул кибер хамгаалалтын стандарт, хариу арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай. Мөн эрчим хүчний хараат байдлыг бууруулах эрх зүйн бодлого нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг юм. Эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдал нь зөвхөн эдийн засгийн бус, стратегийн эрсдэл үүсгэдэг тул эх үүсвэрийн төрөлжилт, дотоодын үйлдвэрлэл, стратегийн нөөц бүрдүүлэх, бүс нутгийн эрчим хүчний сүлжээний хамтын ажиллагааг дэмжих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Мөн стратегийн дэд бүтцийн хамгаалалтын эрх зүйн орчныг бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой. Үүнд эрчим хүч, төмөр зам, харилцаа холбоо, уул уурхайн томоохон орд, мэдээллийн дата төв зэрэг үндэсний хэмжээний стратегийн объектуудын хамгаалалт, өмчлөл, хөрөнгө оруулалтын хяналт, онцгой нөхцөлд ашиглалтын эрх зүйн зохицуулалт багтана. Стратегийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн баталгаа нь үндэсний эдийн засаг, батлан хамгаалах чадавх, нийгмийн тогтвортой байдлын суурь нөхцөл болдог.

ДҮГНЭЛТ

Орчин үеийн үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчин нь уламжлалт ойлголтын хүрээнээс давж, улс орны тогтвортой хөгжил, эдийн засгийн бие даасан байдал, технологийн чадавх, нийгмийн дархлаа, институцийн тогтвортой байдлыг хамарсан нэгдмэл, олон хэмжигдэхүүнт систем болон хувьсан хөгжиж байна. Технологийн хувьсгал, эдийн засаг, кибер болон мэдээллийн орчны заналхийлэл эрчимжиж буй нөхцөлд аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь зөвхөн хамгаалах шинжтэй бус, улс орны хөгжлийн стратеги, өрсөлдөх чадвар, бүрэн эрхт байдлыг баталгаажуулах суурь институцийн механизм болж байна.

АНУ, ХБНГУ зэрэг улсуудын үндэсний аюулгүй байдлын эрх зүйн бодлого, институцийн туршлагаас харахад аюулгүй байдлын эрх зүй нь стратеги төлөвлөлт, эдийн засгийн тогтвортой байдал, технологийн шинэчлэл, эрчим хүчний хараат байдлыг бууруулах бодлого, олон улсын хамтын ажиллагааны механизмын огтлолцол дээр хөгжиж байдаг нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын эрх зүйн тогтолцоо нь төрийн нэгдмэл бодлого, институцийн чадавх, бүс нутгийн улс орнуудын стратеги тогтолцоонд тулгуурласан шинжтэй систем юм.

Монгол Улсын хувьд геостратегийн хувьд давуу болон сул талтай байршил, хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй экспортын гарц хязгаарлагдмал,

эрчим хүч болон дэд бүтцийн хэт хараат байдал зэрэг нь үндэсний аюулгүй байдлын эрх зүйн бодлогыг илүү нарийн тэнцвэртэй, урт хугацааны стратегийн төлөвлөлтөд суурилуулах шаардлагыг бий болгож байна. Мөн кибер орон зай, мэдээлэл, стратегийн дэд бүтэц болон нийлүүлэлтийн тасралтгүй байдал зэрэг нь орчин цагийн аюулгүй байдлын сорилтыг нэмэгдүүлсээр байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтыг системийн түвшинд шинэчлэх шаардлагыг улам тодотгож байгаа явдал юм.

Иймд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эрх зүйн шинэчлэлийг дараах гурван тулгуур зарчимд суурилуулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Нэгдүгээрт, ардчилсан институцийн тогтвортой байдал, эрх мэдлийн хяналт-тэнцэл, хууль дээдлэх зарчмыг бэхжүүлэх замаар аюулгүй байдлын дотоод дархлааг баталгаажуулах; хоёрдугаарт, олон улсын эрх зүй, бүс нутгийн хамтын аюулгүй байдлын механизмд идэвхтэй оролцох, итгэлцэл бэхжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар гадаад орчны стратегийн эрсдэлийг бууруулах; гуравдугаарт, батлан хамгаалах, эдийн засаг, эрчим хүч, кибер орон зай, стратегийн дэд бүтцийг хамарсан “нэгдмэл аюулгүй байдлын” эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Эцэст нь, үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин нь зөвхөн хамгаалах шинжтэй тогтолцоо бус, Монгол Улсын оршин тогтнох, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, урт хугацааны тогтвортой хөгжлийн стратегийн баталгааг бүрдүүлэх нөхцөл мөн бөгөөд уг тогтолцоог шинжлэх ухаанч үндэслэл, геополитикийн бодит үнэлгээ, олон улсын эрх зүйн хандлагатай уялдуулан боловсронгуй болгох нь үндэсний язгуур ашиг сонирхлын тэргүүлэх зорилт гэж үзэх үндэслэлтэй байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Buzan, Barry. 1998. *Ole Wæver, and Jaap de Wilde, Security: A New Framework for Analysis*.
2. 2002. *Homeland Security Act*. Homeland Security Act of 2002, U.S. Congress.
3. 1947. “National Security Act.” *National Security Act*. Washington, DC: U.S. Congress, Government Printing Office.
4. 2022. *National Security Strategy*. National Security Strategy, Washington, DC: The White House.
5. 2023. *National Security Strategy of Germany*. National Security Strategy, Berlin: Federal Government of Germany.
6. 2021. “National Security Strategy of the Russian Federation.” *National Security Strategy of the Russian Federation*. Moscow: Russian Federation.
7. 2022. “Strategic Concept of NATO.” *NATO 2022 Strategic Concept*. Brussels: North Atlantic Treaty Organization.
8. 1979. “Theory of International Politics.” *Addison-Wesley*. Kenneth N. Waltz.
9. 2020. “Алсын хараа-2050.” *Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар: Монгол Улсын Засгийн газар.
10. Батбаяр. 2026. “ҮАБ-ын бодлого, урт хугацааны хөтөлбөрийн эрх зүйд хийсэн шинжилгээ.” *Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал*, 12.
11. 2010. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.” *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*. Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал.
12. 2010. *Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*. Үндэсний бодлого, Монгол Улсын Их Хурал.